

## Төслийн нэр: Эцэг эхчүүдэд зориулсан “Номтой цаг” хөтөлбөр

### Хэсэг I: Төсөл санаачлагчийн мэдээлэл

Аймаг/ хот: Архангай аймаг
Сум /дүүрэг: Эрдэнэбулган сум
СЭЭБХ-ны хаяг: 4-р сургууль
СЭЭБХ-ны зохицуулагчийн овог, нэр: Н.Бямбадулам

### Хэсэг IIa. Нөхцөл байдлын шинжилгээ

Дотоод хүчин зүйлс	
<b>Давуу тал</b> 1. СЭЭБХ-ны талаарх ойлголттой эцэг эхчүүдийн тоо олон 3. СЭЭБХ-ны үйл ажиллагааг дэмждэг эцэг эхчүүд олон байдаг. 4. Гэртээ ажилгүй суудаг эцэг эхчүүдийн тоо олон учир үйл ажиллагаанд татан оролцуулах боломж бий	<b>Сул тал</b> 1. Малчин эцэг эхчүүд олон байдаг учир эцэг эхчүүдийн оролцоог 100% хангаж чаддаггүй. 2. Эцэг эхчүүдтэй хамтарч ажиллахад хүндрэлтэй. 3. Боловсролгүй эцэг эхчүүд олон байдаг учраас ирсэн сонссон зүйлээ өөрийн болгож түгээн дэлгэрүүлэх тал дээр сул 4. Эцэг эхийн хурлын ирц байнга муу байдаг
Гадаад хүчин зүйлс	
<b>Боломж</b> 1. СЭЭБХ-ны үйл ажиллагааг жигдэрүүлсэнээр эцэг эхчүүдийн оролцооны түвшин нэмэгдэнэ. 2. СЭЭБХ-ны талаарх мэдээллийг авч чаддаггүй малчин эцэг эхчүүдэд мэдээллэл хүргэх боломж нэмэгдэнэ. 3. Эцэг эхчүүд хүүхдүүддээ тавих анхаарал халамж сайжирна.	<b>Эрсдэл</b> 1. Төрийн ажил хийдэг эцэг эхчүүдийг хамруулахад ажилтай гээд ирэхгүй байх. 2. Идэвхтэй эцэг эхчүүд нь боловсролын түвшин доогуур 3. Сургууль дээр очиж хуралд сууна гэдгийг мөнгө хураана гэж ойлгоод ирэхгүй байх хандлага их 4. Багштай утсаар ярьж асуудлаа шийддэг эцэг эхчүүдийг хамруулах боломжгүй.

### Хэсэг IIб. Төслийн зорилго, хамрах хүрээ

Зорилго	Эцэг эхчүүдэд зориулсан “Номтой цаг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар сургууль, эцэг эх, багшийн хамтын ажиллагааг сайжруулж, эцэг эхийн зүгээс хүүхдэдээ анхаарал хандуулах цагтай болгоно.
Хамрагдах хүний тоо	Бага ангийн багш, СЭЭБХ-ны гишүүн болон бусад эцэг эх, сургуулийн удирдлагын баг

### Хэсэг III. Төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалт ба ажлын төлөвлөгөө

№	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн	Хугацаа	Хүрэх үр дүн
1.	Төслийн нээлтийн үйл ажиллагаа	СЭЭБХ-ны УЗ	2019 оны 6-р сард	Аймгийн удирдлагууд, эцэг эх, багш нарыг нээлтийн үйл ажиллагаанд урьж, СЭЭБХ-ны үйл ажиллагаа ач холбогдлыг танилцуулахаас гадна төслийн хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулна.

Сургуулийн удирдлага, эцэг эх, багшийн хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд				
2.	Эцэг эхийн оролцоотойгоор “Номын өргөө” байгуулах	Сургуулийн удирдлага, СЭЭБХ-ны гишүүд	2019 оны 9-р сард	Сургууль дээр эцэг эхэд зориулсан “Номын өргөө”-тэй болсноор эцэг эхийн оролцоо нэмэгдэж, төслийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.
3.	Төслийн үйл ажиллагааг таниулах зорилготой сурвалжлах баг гаргах, багт зориулж сургалт зохион байгуулна.	СЭЭБХ, Аймгийн Хэвлэл мэдээллийн байгууллагаас дэмжлэг авна.	2019 оны 9-р сард	<ul style="list-style-type: none"> <li>Төслийн үйл ажиллагаа бүрийг түгээх, сурталчлах “Эцэг эхийн сурвалжлах баг” гаргана.</li> <li>Бичих сонирхолтой эцэг эхийг сайн дурын үндсэн дээр энэ багт шалгаруулж авна. Сурвалжлах багийн бүтээлийг Sainsurguuli.mn сайт болон Сайн сургуулиас сайхан амьдрал эхэлнэ фэйсбүүк хуудсанд байршуулж, орон даяар түгээнэ.</li> <li>Мөн аймгийн ХМХ-ээр түгээнэ. Эцэг эхчүүдэд тараах материал байдлаар түгээнэ.</li> <li>Сургалтыг аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагаас арга зүйн дэмжлэг авч зохион байгуулна.</li> </ul>
4.	Эцэг эх орон нутгийн хамтын ажиллагаа сургалт, хэлэлцүүлэг	Сургуулийн удирдлага, ЗДТГ-тай хамтрана.	2019.10-р сард	Аймаг, сумын удирдлагуудтай хэрхэн хамтарч ажиллах тухай арга зүйн сургалтанд хамрагдаж, аймаг, сумын удирдлагуудтай хэлэлцүүлэг өрнүүлнэ. Хэлэлцүүлгийн үр дүнд хамтран ажиллах боломжуудыг ярилцаж, тохирно.
5.	Хүүхдийн эрх, хамгаалал, хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудаас туршлага судлах	Хүүхдийг ивээх сангийн “Хүүхэд хамгааллын арга зүйн төв”, Чингэлтэй дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн төв, Гэр бүл, хүүхэд, залуучуудын	2019.9.24-27	Улаанбаатарт үйл ажиллагаа явуулдаг Хүний эрх, хүүхдийн эрх, боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн, олон улсын болон үндэсний 5 ТББ-аар зочилж, үйл ажиллагаатай нь танилцаж, туршлага судална. Энэ бүх үйл явцыг сурвалжлах баг баримтжуулна.

		хөгжлийн газар, “Хүүхэд, өсвөр үеийг ивээх” төв		
6.	Туршлага судлах хөтөлбөрт оролцогчид төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх	СЭЭБХ-ны төлөөллүүд	2019.10-р сар	Сургалт болон туршлага судлах хөтөлбөрийн хүрээнд сурсан зүйлээ өөрийн орон нутаг, эцэг эхчүүдэд хэрхэн түгээх, СЭЭБХ цаашид хэрхэн ажиллах талаар урт хугацааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.
<b>Эцэг эхийн зүгээс хүүхэдтэйгээ хамтран ажиллах цагийг нэмэгдүүлэх хүрээнд</b>				
7.	Судалсан мэдлэг, ойлголт, туршлагаа хуваалцах уулзалт зохион байгуулах	СЭЭБХ-ны төлөөллүүд	2019.10-р сар	СЭЭБХ-ны гишүүдийн чадавх сайжирч, бусад эцэг эхийн оролцоо нэмэгдэнэ.
8.	Сурвалжлах багийн бүтээлийг эцэг эхчүүдэд түгээх	СЭЭБХ, Аймгийн ХМБ	2019.10-2020.5-р сар	Туршлага судлах аялалын тэмдэглэл болон төслийн хүрээнд зохион байгуулагдсан бусад үйл ажиллагааг сурвалжлах багийн гишүүд тогтмол хугацаанд бичиж, нийтлэн эцэг эхчүүдэд хүргэж байна. Бүтээлээ аймгийн Хэвлэл мэдээллийн байгууллагууд болон сургуулийн нэгдсэн фэйсбүүк группт байршуулах, хэвлэмэл материал болгон тараах зэрэг олон хувилбараар хүргэнэ.
9.	“Номтой цаг” хэлэлцүүлэг	СЭЭБХ	Сар бүр	Эцэг эхчүүдийн дунд уншсан номын сэдэв бүрээр хэлэлцүүлэг өрнүүлдэг болно. Тогтмол зохион байгуулж, эцэг эхчүүдийн хүсэн хүлээдэг, тогтмол оролцдог үйл ажиллагаа болгоно.
10.	Эцэг эхчүүдийн дунд мэргэжил бүхэн сайхан аян өрнүүлнэ.	СЭЭБХ	2019.12-р сард	Эцэг эхчүүд өөрсдийнхөө хийдэг ажлыг сурталчлах заавал мэргэжилтэй дээд боловсролтой болох нь тийм ч сайн зүйл биш харин ямар нэг зүйлийг сайн хийж чаддаг байх нь чухал гэдгийг ойлгуулах.
11.	“Номтой өдөр” бага ангийн бүх хүүхдэд хуваарь гарган эцэг эхтэйгээ хамт ном унших, ярих аяныг өрнүүлнэ.	СЭЭБХ, Номын санч БАЗАН	Төслийн туршид тогтмол	БЧШ төслийн хүрээнд сургуулийн захиалсан номнуудыг ашиглан 1-5р ангийн бүлэг бүрийн хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон номнуудыг бүлэглэн хүүхдэд уншуулах хууварь гаргаж

				уншуулна. Ингэхдээ эцэг эхчүүдийг татан оролцуулна. Төсөл дуусахад бага ангийн бүх эцэг эх, хүүхэдтэйгээ хамт нэг ном уншиж, тэмдэглэл хөтлөн, түүнийхээ тухай ярилцсан байна.
12.	Үр дүнгийн тайлан	СЭЭБХ	2020.4-р сарын сүүлийн хагаст	Төслийн хугацаанд хийсэн үйл ажиллагааг тайлагнах, цаашид Хүүхэд-гэр бүл хөгжлийн өргөөг идэвхтэй, үр дүнтэй ажиллуулах төлөвлөлтөд санал, хүсэлт авна.

#### Хэсэг IV Зардлын задаргаа


Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ, төг	Нийт үнэ, төг	Хүрэх үр дүн
Төслийн нээлтийн үйл ажиллагаа <ul style="list-style-type: none"> <li>• Баннер</li> <li>• Станд</li> <li>• Цайны материал</li> </ul>				150 000₮	Аймгийн удирдлагууд, эцэг эх, багш нарыг нээлтийн үйл ажиллагаанд урьж, СЭЭБХ-ны үйл ажиллагаа ач холбогдлыг танилцуулахаас гадна төслийн хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулна.
Номын өргөө байгуулах <ul style="list-style-type: none"> <li>• Өнгөт принтер</li> <li>• Ламинатор</li> <li>• Мэдээллийн самбар хийлгэх</li> <li>• Дуу хураагуур</li> </ul>	Ш	1	500 000₮	500 000₮	Эцэг эх, хүүхэд хамтран ном уншуулах, сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах боломжтой болно.
	Ш	1	120 000₮	120 000₮	
	Ш	2	50 000₮	100 000₮	
	Ш	1	120 000₮	120 000₮	
Сурвалжлах багт зориулсан сургалт	Удаа	1	100 000₮	100 000₮	Сургалтын хоол болон сургагч багшийн урамшуулал багтсан болно.
Эцэг эх, орон нутгийн хамтын ажиллагаа сургалт	Удаа	1	100 000	100 000₮	Сургалтын хоол болон сургагч багшийн урамшуулал багтсан болно.
Эцэг эх, орон нутгийн хамтын ажиллагаа хэлэлцүүлэг	Удаа	1	200 000	200 000₮	Аймгийн тамгын газрын хурлын танхимд зохион байгуулж аймгийн удирдлагуудыг урьж оролцуулна. Тодорхой хамтран ажиллах шийдлүүдэд хүрнэ.
Туршлага судлах хөтөлбөрийн зардал	Удаа	1		945 000₮	УБ хотод байрлах, унаа болон бусад зардал
Туршлага судлах хөтөлбөрийн унааны зардал	2 талд	5	50 000	250 000₮	

Туршлага судлах хөтөлбөрийн томилолтын зардал	хоног	4	30 000-нэг хүнд	120 000*5= 600 000₮	Томилолтын зардал
СЭЭБХ-ны гишүүд өөрийн орон нутгийн эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулна.	удаа	5	100 000	500 000₮	Сургалт зохион байгуулах зардал
Ном ба хүүхэд аян	Удаа	10	60 000	600 000₮	Эцэг эх, хүүхдийн уншсан ном тус бүрээр сонирхолтой хэлэлцүүлэг өрнүүлнэ.
Номын худалдан авалт	Ш	50	10 000	500 000₮	Эцэг эх, хүүхдийн эрэлт хэрэгцээнт нийцсэн агуулга бүхий номнуудыг худалдан авна. Жишээ нь: Хүмүүжлийн эерэг арга, хүүхдийнхээ нас сэтгэхүйн онцлогийг ойлгож мэдрэмжтэй хандах тухай
Бичиг хэрэг				200 000₮	Төсөл хэрэгжүүлэх үйл явцад зориулагдана.
Харилцаа холбооны зардал				200 000₮	
Үйл ажиллагааны зардал				117 000₮	
Банкны шимтгэл				30 000₮	
<b>Бүгд</b>				<b>2666\$*2000=5 332 000</b>	

**Хэсэг VI** Төслийн тогтвортой байдал

СЭЭБХ-ны гишүүд чадавхжих, иргэний нийгмийн байгууллагын нэг хэсэг болохоо ухамсарлаж, эцэг эхийн оролцоо нэмэгдсэнээр СЭЭБХ-ны бте даасан байдал нэмэгдэж, аймгийн түвшинд ажилладаг хамгийн нөлөө бүхий эцэг эхийн байгууллагын загвар болно.

Төслийн саналыг дэмжсэн гишүүдийн гарын үсэг, нэр :

СЭЭБХ-ны Зохицуулагч: Нэр <i>Н.Бямбадулам</i>		Гарын үсэг..... <i>Н.Бямбадулам</i>
Төслийг боловсруулсан:	Эцэг эх /Н.Бямбадулам/ Эцэг эх /Д.Ууганзаяа/ Эцэг эх /Д.Отгонбаяр/ Эцэг эх /С.Содбаатар/ Багш /Д.Шинэбилэг/ Багш /Г.Должинсүрэн/ Багш /Д.Батчимэг/ Багш /Ж.Өнөржаргал	Огноо: 2019...он 01 сарын 22 өдөр 
	Гарын үсэг..... <i>Н.Бямбадулам</i>	